

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын сэдэв: Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: АЙМГИЙН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ДАВЖ
БИЕЛСЭН БОЛОВЧ НОГДУУЛСАН ОРЛОГЫН 16.4 ХУВИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ,
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Аудитын код: ОРА-2025/27-12-ШТА-ГА

Цахим хуудас: www.audit.mn	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: В.Жавзмаа Утас: 70350757 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn Аудитор: Г.Даваасүрэн Утас: 70350757 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn Аудитор: Ж.Наранчимэг Утас: 70350757 Цахим хаяг: naranchimegi@audit.gov.mn
Эрдэнэт хот 2025 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Тушаал.....	2
Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг	4
Дүрслэлийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. Хүү, торгуулийн орлогыг урьдчилан тооцоолж, бодит гүйцэтгэлд үндэслэн төлөвлөх нөхцөл бүрдээгүй байна.	8
1.1. Хүү, торгуулийн орлогын төлөвлөх бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох боломжгүй байна.....	8
1.2 Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, судалгаа тооцоонд үндэслэхгүй төлөвлөж байна.....	10
1.3 Торгуулийн орлого бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах хэрэгтэй байна.	12
БҮЛЭГ 2. Төлөвлөсөн торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелсэн боловч орлого бүрэн төвлөрөөгүйд анхаарахаар байна.	15
2.1 Төлөвлөсөн торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелсэн боловч орлого бүрэн төвлөрөөгүйд анхаарахаар байна.....	15
2.2 Торгуулиас бүрдсэн орлогыг хуваарилахдаа хууль, журамд заасантай нийцүүлээгүй байна.....	19
БҮЛЭГ 3. Торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэхийг тооцоогүй байна.....	20
3.1. Хүү, торгуулийн орлогоос Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023-2024 онд 868.7 сая төгрөг зарцуулж, үр дүнг тооцоогүй байна.	20
3.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлсэн байна.....	23
БҮЛЭГ 4. Хүү, торгуулийн орлогын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан үүсээгүй, түүний бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.	24
4.1 Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан үүсээгүй байна.	24
4.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.....	25
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	26
ЗӨВЛӨМЖ:.....	27
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:.....	28
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	29

Тушаал



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/17

Эрдэнэт

Г Аудитын тайлан баталгаажуулах Г
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ОРА-2025/27-12-ШТА-ГА/-г баталгаажуулсугай.
2. Аудитын зөрчил, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Нийслэлийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Татварын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2026 оны 04 сарын 05-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Д.Мөнхбат) аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр), Татварын газрын дарга (Б.Цэвээнсүрэн), Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ш.Баасандорж), Цагдаагийн газрын дарга, хурандаа (А.Лхагвадорж) нарт зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Буян-Ундрах), ахлах аудитор (В.Жавзмаа), аудитор (Г.Даваасүрэн), аудитор (Ж.Наранчимэг) нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

D:\my doc\bichig hereg\ tushaal\2025.doc

Орхон аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, төргүүлэх аудиторын
2025 оны 07 дугаар сарын 30-ны
өдрийн /11/ дугаар тушаалын хавсралт

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” гүйцэтгэлийн аудитаар
илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт 5042806

/мянган төгрөгөөр/

Дугаар	Зөрчлийн товч утга	Дүн	Шийдвэр	Хариуцах байгууллага
239/A1460335 ОРА-2025/27-12-ШТА-ГА	Торгуулийн орлого төвлөрүүлээгүй	10,800.0	Албан шаардлага	Аймгийн Онцгой байдлын газар
240/A1460335 ОРА-2025/27-12-ШТА-ГА	Торгуулийн орлого төвлөрүүлээгүй	44,750.0	Албан шаардлага	Аймгийн Цагдаагийн газар
Нийт дүн		55,550.0		

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улс, орон нутгийн орлого 2023-2024 он	6
Хүснэгт 2	Хүүгийн орлого	7
Хүснэгт 3	Торгуулийн орлого ногдуулалт	8
Хүснэгт 4	Торгуулийн орлого	9
Хүснэгт 5	Торгуулийн орлогын ногдуулалт, биелэлт	10
Хүснэгт 6	Аймгийн торгуулийн орлогын ногдуулалт, төвлөрүүлсэн орлого	15
Хүснэгт 7	Аймаг, сумын торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2023, 2024 он	16
Хүснэгт 8	Аймгийн төсвийн нийт орлого, торгуулийн орлогын судалгаа	17
Хүснэгт 9	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийн төлөвлөгөө	18
Хүснэгт 10	Гэмт хэргийн статистик тоо	21

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Улс, орон нутгийн орлого 2023-2024 он	16
Дүрслэл 2	Торгуулийн орлогын орон нутгийн төсөвт эзлэх хувь	17

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. • Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх; • Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх; • Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх; • Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэх холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалд тулгуурлан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторовын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт,

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл	тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгааны арга зүйг мөрдөж ажиллав. Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно. Аудитад дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд: • Төсвийн тухай хууль; • Нийгмийн даатгалын багц хуулиуд; • Татварын багц хуулиуд; • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; • Гаалийн ерөнхий хууль; • Засгийн газрын тусгай сангийн тухай хууль; • Автозамын тухай хууль; • Зөрчлийн тухай хууль; • Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль; • Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль; • Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль; • Байгаль орчныг хамгаалах тухай хууль; • Төрийн аудитын тухай хууль; • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; • Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”; • Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”; • Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”; • Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Г.Даваасүрэн, Ж.Наранчимэг нар 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв. Аудит хийхэд хүндрэл бэрхшээл учраагүй болно.
--	--

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрддэг. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.7.2-т “орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого” гэж зохицуулсан.

Зөрчлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1-т “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ”, 3 дугаар зүйлийн 3.4-т “Торгох шийтгэл”, 3.4.1-т “Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ” гэж заасны дагуу орон нутгийн татварын бус орлогод торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2 -т заажээ.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч “хүү, торгуулийн орлого” гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнаж байна.

Улсын төсвийн орлого болон Орхон аймгийн төсвийн орлогыг 2023, 2024 оноор харьцуулан харуулбал:

Хүснэгт 1 Улс, орон нутгийн орлого 2023-2024 он

(сая төгрөг)

	Улсын төсөв			Орон нутгийн төсөв		
	2023 он	2024 он	Өсөлт хувиар	2023 он	2024 он	Өсөлт хувиар
Татварын орлого	21,484,155.0	27,377,483.8	27.4	257,455.4	245,965.1	(4.4)
Татварын бус орлого	1,451,747.0	1,769,842.6	21.9	29,551.3	65,487.8	120.8
Хүү, торгуулийн орлого				2,090.5	2,303.1	10.1

Хүснэгтээс харахад татварын бус орлогын 3.5-7.8 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна. Дээрх орлого 2023 онд 2,090.5 сая төгрөг байсан бол 2024 онд 2,303.1 сая төгрөг болж 10.1 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг 29 байгууллагын 215 эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэгч 17 байгууллага байдгаас 39.6 сая төгрөгийг улсын төсөвт, 4,295.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлсэн байна.

Торгуулийн орлогын тодорхой хэсгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон замын санд төлөвлөн, зарцуулах хуулийн зохицуулалтын дагуу аймгийн ИТХ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023 онд 596.0 сая, 2024 онд 780.0 сая төгрөгийг баталж, нийт 868.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

БҮЛЭГ 1. Хүү, торгуулийн орлогыг урьдчилан тооцоолж, бодит гүйцэтгэлд үндэслэн төлөвлөх нөхцөл бүрдээгүй байна.

1.1. Хүү, торгуулийн орлогын төлөвлөх бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох боломжгүй байна.

1.1.1. Хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.

Орон нутгийн төсвийн орлогод хүүгийн орлого төвлөрүүлэх төсөв төлөвлөж батлаагүй ба аймгийн хэмжээнд хүү тооцох харилцах данс арилжааны банканд нээгээгүй байна.

Нийгмийн даатгалын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хүүгийн орлого төвлөрүүлдэг ба тухайн байгууллагууд харилцах дансны үлдэгдлийг тодорхойлох боломжгүйгээс хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.

Хүснэгт 2 Хүүгийн орлого		(сая төгрөг)			
№	Байгууллагын нэр	2023 он		2024 он	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Нийгмийн даатгалын газар	0.0	105.5	0.0	103.0
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	0.0	1.6	0.0	7.4
3	Баян-өндөр сумын ХХСан	0.0	30.8	0.0	21.1
4	Жаргалант сумын ХХСан	0.0	5.2	0.0	5.4
	ДҮН		143.1		136.9

Харин Баян-Өндөр, Жаргалант сумдын хоршоо хөгжүүлэх сангууд нь хүүгийн орлого төвлөрүүлдэг бөгөөд хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн “Хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.1¹, 2.1.3², 2.1.4³-т заасантай нийцэхгүй байна.

1.1.2. Торгуулийн орлогыг хуулийн дагуу төлөвлөх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох боломжгүй байна.

Аймгийн 2023, 2024 оны төсвийг төлөвлөхдөө Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймаг, сумын төсвийн орлогыг “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д зааснаар төсвийн төсөлд орлогыг нэр, төрлөөр тооцох зохицуулалттай боловч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5⁴-д заасны дагуу зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд торгуулийн орлогыг төлөвлөдөггүй байна.

¹ 2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

² 2.1.3. сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр

³ 2.1.4. сангаас аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр

⁴ 9.5 -д “хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй”

Аймгийн төсвийн торгуулийн орлогыг 2023 онд 1,490.0 сая төгрөгөөр, 2024 онд 1,950.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөж баталсан байна.

Торгуулийн орлого жил бүр төлөвлөгөөнөөс давж биелэн, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг 1,690.0 -2,300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зарим зардлын эх үүсвэр болж байгаа ч Сангийн яамнаас хянасан дүнгээр баталж байна.

Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, зөрчлийн тоо зэргийг харгалзан, төсвийн шаардлагад нийцүүлж төлөвлөх нь иргэдэд торгуулийн дарамт үүсгэж, төлөхгүй байх эрсдэл үүсгэхээр байна.

Аймгийн торгуулийн нийт орлогын 50-70 хувийг бүрдүүлдэг Татварын газрын 2024 оны ногдуулалт өмнөх оноос 40.9 хувиар буюу 696.0 сая төгрөгөөр өсөж, Цагдаагийн газрын 2024 оны ногдуулалт өмнөх оноос 40.3 хувиар буюу 488.7 сая төгрөгөөр буурсан байна.

Мөн нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн зохицуулалтаас шалтгаалан бодитой төлөвлөхөд эрсдэл үүсгэхээр байгаа нь аудитын судалгаанаас харагдаж байна.

Хүснэгт 3 Торгуулийн орлогын ногдуулалт

(сая төгрөг)

Д/д	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	2023 он		2024 он		Зөрүү	Хувиар
		Ногдуулсан	тоо	Ногдуулсан	тоо		
1	Орхон Авто тээврийн төв	3.1	20	6.8	49	3.7	45.7
2	Аймгийн ЗДТГазар	1.6	4	20.1	17	18.5	8.0
3	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	14.2	23	2.0	3	(12.2)	694.1
4	Орхон дахь гаалийн газар	8.6	6	2.0	1	(6.6)	430.0
5	Орхон аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	6.5	19	54.6	32	48.0	12.0
6	Орхон Нийгмийн даатгалын газар	19.3	59	8.9	34	(10.3)	215.7
7	Онцгой байдлын газар	3.2	21	14.2	30	11.0	22.5
8	Орхон Татварын газар	480.9	232	1,176.9	262	696.0	40.9
9	Орхон Улсын бүртгэлийн хэлтэс	4.8	176	6.0	173	1.2	78.6
10	Орхон Хүнс хөдөө аж ахуйн газар	3.8	4	0.3	1	(3.5)	1266.7
11	Орхон Эрүүл мэндийн газар	6.1	8	9.7	13	3.6	63.5
12	Орхон Мал эмнэлгийн газар	0.3	2	0.2	1	(0.1)	200.0
13	Дотоодын цэрэг 816 анги	-	0	2.2	21	2.2	0.0
14	Дотоодын цэрэг 821 анги	-		0.4	4	0.4	0.0
15	Орхон Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	26.7	14	29.7	18	3.0	89.8
16	Орхон аймаг дахь төрийн аудитын газар	158.4	136	170.9	179	12.5	92.7
17	Орхон аймгийн цагдаагийн газар	1,701.0	45935	1,212.3	41482	(488.7)	140.3

1.2 Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, судалгаа тооцоонд үндэслэхгүй төлөвлөж байна.

1.2.1. Торгуулийн орлогын биелэлт жил бүр давж биелсэн байна.

Аймгийн торгуулийн орлогын төлөвлөгөө жил бүр биелж, 18.0-40.0 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 4 Торгуулийн орлого

(сая.төгрөг)

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2021	830.0	1,755.2	925.2	211.5
2022	1,430.0	1,690.0	260.0	118.2
2023	1,490.0	2,090.5	600.5	140.3
2024	1,950.0	2,303.1	353.1	118.1

Орон нутгийн торгуулийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сүүлийн 4 жилээр харвал 260.0-925.0 сая төгрөгөөр давж биелсэн байна.

1.2.2. Торгуулийн орлогыг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулахгүй төлөвлөж байна.

Орлогыг төлөвлөхдөө суурь судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэхгүйгээр Сангийн яам хянасан дүнгээр төлөвлөдөг бөгөөд нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн зохицуулалтаас шалтгаалан бодитой төлөвлөхөд эрсдэл үүсгэхээр байна. Орон нутгийн торгуулийн нийт орлогын 50-70 хувийг бүрдүүлдэг Татварын газрын 2024 оны ногдуулалт өмнөх оноос 40.9 хувиар буюу 696.0 сая төгрөгөөр өсөж, Цагдаагийн газрын 2024 оны ногдуулалт өмнөх оноос 40.3 хувиар буюу 488.7 сая төгрөгөөр буурсан нь тодорхойлох боломжгүйг илтгэж байна.

Аймгийн 2023, 2024 оны төсвийн төсөлд торгуулийн орлогыг 1,400.0 сая төгрөгөөр хүргүүлснийг Сангийн яам хянаж, нэмэгдүүлсээр ирсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх байгууллагууд нь тайлант онд төвлөрүүлэх торгуулийн орлогыг урьдчилан тооцоолох боломжгүйгээс торгуулийн орлогыг байгууллагын түвшинд төлөвлөдөггүй бөгөөд аймаг, сумдын төсвийн төсөл боловсруулахдаа төсөвт төвлөрүүлэх хүү, торгуулийн орлогыг хуулийн дагуу нийт дүнгээр төлөвлөн баталж байна.

Аймаг, сумд нь хүү, торгуулийн орлогыг төлөвлөж, торгуулиас орсон орлогыг сар бүр ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

1.2.3. Хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.

Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-7/8/4 дүгээр “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай” тушаалын 1-д “харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосугай” гэж заасан байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудын хувьд байгууллагын дансны чөлөөт үлдэгдэлд 2023, 2024 онд Нийгмийн даатгалын газарт

арилжааны 4 банк 3 хувиар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ХААН банк нөхцөлт шаталсан хүү 0.8-1.2 хувиар хүү тооцсон байна.

Хүүгийн орлого төвлөрүүлж буй төсвийн байгууллагууд хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.

1.2.4. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцсон байна.

Хүүгийн орлого төвлөрүүлдэг байгууллагууд хүүгийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцдоггүй бөгөөд улсын төсөвт төвлөрүүлж, зарцуулдаггүй байна.

Харин сум хөгжүүлэх сангийн хүүгийн орлогыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.7⁵-д заасны дагуу төлөвлөн, батлуулж зарцуулсан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд торгуулийн орлогыг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоолдоггүй байна.

Аймгийн торгуулийн орлогоос аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1⁶-д заасны дагуу төлөвлөсөн байна.

1.2.5. Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан шалтгаан, нөхцөл байдлыг үнэлж дүгнээгүй байна.

Орон нутгийн төсвийн торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл болон торгуулийн ногдуулалт, хэрэгжилтийг 2023-2024 оноор харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 5 Торгуулийн орлогын ногдуулалт, биелэлт

(сая.төгрөг)

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Ногдуулсан торгууль	Хэрэгжсэн	Зөрүү	Хувь
2023	1,490.0	2,090.5	600.5	140.3	2,438.5	2,244.7	(193.8)	92.0
2024	1,950.0	2,303.1	353.1	118.1	2,721.0	2,090.6	(630.4)	76.8

⁵ 2.7 Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 30 хүртэл хувийг хоршоонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хүртэл хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаа болон программ хангамжийн зардалд, 10 хүртэл хувийг аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан байгууллагын саналыг харгалзан сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг урамшуулахад зориулан хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулж болно

⁶ 46.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 5.9 дүгээр зүйл, 5.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 4, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 5.16, 5.18 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 4, 5, 7, 9 дэх хэсэг, 6.21, 6.22 дугаар зүйл, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.8 дугаар зүйл, 10.4, 10.8, 10.26, 10.28 дугаар зүйл, 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 13.5, 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.18 дугаар зүйл, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл, 15.22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

Аудитын явцад хийсэн судалгаанаас үзвэл торгуулийн орлогын төлөвлөгөө 2023 онд 40.3, 2024 онд 18.1 хувиар давж биелсэн хэдий ч эрх бүхий байгууллагын торгууль ногдуулалт, түүний хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

Торгууль оногдуулсан эрх бүхий байгууллагуудаас аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс судалгаа гаргуулан авч хянадаггүй, торгуулийн орлогын төлөвлөгөө давсан, тасарсан шалтгаан нөхцөл байдлыг тодорхойлоогүй, боломжийг үнэлж дүгнээгүй байна.

Торгуулийн орлогыг харилцан адилгүй дансанд төвлөрүүлж байгааг мөн цэгцлэх шаардлагатай бөгөөд Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8.1⁷-д заасантай нийцэхгүй байна. Энэ орон нутгийн хүү, торгуулийн орлого төвлөрүүлэлтэд нөлөөлж байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4⁸, 31.4.5⁹ -д заасны дагуу торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж хэрэгтэй байна.

1.2.6. Орлогын эх үүсвэрийг тооцсон байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9¹⁰, 14 дүгээр зүйлийн 14.2¹¹, 14.2.1¹², 27 дугаар зүйлийн 27.1¹³, 27.1.4¹⁴ дах заалтуудад аймгийн хүү, торгуулийн орлогыг эх үүсвэр байхаар заасан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийг бэлтгэн хүргэхдээ торгуулийн орлогыг 2023, 2024 онд 1,400.0 сая төгрөгөөр тусган хүргүүлж, Сангийн яамны хянасан дүнгээр баталсан байна.

Аймгийн торгуулийн орлогын эх үүсвэрийг Татварын газар, Цагдаагийн газрын үйл ажиллагаанаас бүрдүүлэхээр төлөвлөсөн ба энэ нь орон нутгийн төсөвт төвлөрсөн нийт торгуулийн орлогын 85.0-90.0 хувийг эзэлдэгтэй холбоотой байна.

1.3 Торгуулийн орлого бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах хэрэгтэй байна.

1.3.1. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин харилцан уялдаатай байхаар тодорхойлсон байна.

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг зохицуулж буй эрх зүйн орчин нь Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авто замын тухай зэрэг хуулиуд, холбогдох салбарын бодлого, журмуудаас хамаарч байна.

⁷ 1.8.1 зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна"

⁸ 31.4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана",

⁹ 31.4.5 Төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээний тайлан болон тухайн жилийн төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн урьдчилсан тооцоо

¹⁰ 4.1.9 Төсвийн орлого гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг

¹¹ 14.2 Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

¹² 14.2.1 Жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах

¹³ 27.1 Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана

¹⁴ 27.1.4 Жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх

Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар торгох шийтгэлээр шийтгүүлсэн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийг хангуулах процесс нь харилцан уялдаатай байхаар тодорхойлсон байна.

1.3.2. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ хуульчилсан байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5¹⁵-д заасны дагуу Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А/106/298 дугаар хамтарсан тушаалаар “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ыг баталж, хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчилсан байна.

Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-7/8/4 дүгээр “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай” тушаалын 1-д “харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосугай” гэж заасан.

1.3.3. Тодорхойгүй заалтууд орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Төсвийн тухай хуулиар хүү, торгуулийн орлого нь аймаг болон сумын төсвийн татварын бус орлогод төвлөрөхөөр тодорхой заасан байдаг хэдий ч салбарын хуулиараа зохицуулдаг хүү, торгууль байна. Тухайлбал Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1¹⁶, 11.1.5¹⁷-д заасан торгуулийн орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж буй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2¹⁸-дах заалттай нийцэхгүй байна.

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтэд нөлөөлж буй тодорхойгүй асуудлыг хууль, журамд тусгахаар дараах асуудлууд байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих тодорхой заалт байхгүй байна.
- Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд татварын бус, торгуулийн орлогыг төлөвлөх, ямар арга хэмжээнд зарцуулах талаар тодорхой тусгаагүй байна.
- "Зөрчлийн тухай хууль"-д зааснаар, зөрчил үйлдсэн этгээдэд торгууль ногдуулах, албадлагын арга хэмжээ авах, торгууль төлөлт, хөнгөлөлт эдлэх зэрэг зохицуулалтыг Төсвийн тухай хууль, журмуудтай уялдуулах.

Оногдуулсан торгуулийг санаатайгаар төлөөгүй байх, иргэний оршин суугаа газар тодорхойгүй байдал зэрэг нь торгуулийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр

¹⁵ 13.5 хадгаламжийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина

¹⁶ 11.1. Нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

¹⁷ 11.1.5 нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, торгууль;

¹⁸ 23.7.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

нөлөөлж байгаад дүн шинжилгээ хийж, төрийн цахим үйлчилгээг хоорондоо уялдаатай, шуурхай болгох саналыг холбогдох газарт уламжлахаар шийдвэрлэв.

1.3.4. Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нийцсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1¹⁹, 1.1²⁰, 1.7²¹-д заасны дагуу хяналт тавихаар заасны дагуу аймгийн Прокурорын газраас 2023 онд 2,166, 2024 онд 1,272 зөрчлийн хэрэг бүртгэлтийг хянасан байна. Тухайн хяналтаар хууль, журамд заасан үндэслэлийг буруу хэрэглэсэн, нотлох баримт дутуу шалтгааны улмаас 2023 онд 7, 2024 онд 7, нийт 14 дүгнэлт бичиж, хүчингүй болгон, 2023 онд 38, 2024 онд 11, нийт 49 шийтгэврийн зүйл заалт өөрчлөх санал дүгнэлт гаргасан байна.

Эндээс дүгнэвэл хүчингүй болгох, өөрчлөх дүгнэлт гаргасан зөрчлийн тоо 2023 онд нийт зөрчлийн 2.0 хувь байсан бол 2024 онд 1.4 хувьд хүрч буурсан торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нийцээгүй торгууль оногдуулаагүй бөгөөд эрх бүхий албан тушаалтны хариуцлага дээшилж буйг илтгэж байна.

Аудитын судалгааг эрх бүхий байгууллагын зөрчил шалган шийдвэрлэсэн материалтай тулган баталгаажуулахад, торгуулийн хэмжээ, торгосон үндэслэл нь Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалттай нийцсэн, зөрчлийн шинжид тохирч байсан болно.

1.3.5. Хуулийн хэрэглээ эрх бүхий албан тушаалтнаас шалтгаалж байгаад анхаарахаар байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Зөрчлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна”, 2 дахь хэсэгт “энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл ногдуулна” гэж заасан.

Прокурорын газраас 2023-2024 оны 3,438 зөрчлийн хэрэг бүртгэлтийг хянаж, хууль, журамд заасан үндэслэлийг буруу хэрэглэсэн, нотлох баримт дутуу шалтгааны улмаас нийт 14 дүгнэлт бичиж, хүчингүй болгон, 49 шийтгэврийн зүйл заалт өөрчлөх санал дүгнэлт гаргаснаас дүгнэвэл эрх бүхий албан тушаалтнууд зөрчлийг хэрхэн илрүүлж байгаагаас шалтгаалан адил тэгш үйлчилж байгаа эсэх нь хамаарч байна. Иймд эрх бүхий албан тушаалтнуудын хууль, эрхийн актын мэдлэг, ур чадварыг сайжруулах, цахим системээр зөрчил бүртгэх, хянах, сургах асуудлыг үе шаттай зохион байгуулах шаардлагатай байна.

Мөн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлууд аймгийн хэмжээнд байсаар байтал тухайн чиглэлийн зөрчил 2023 онд 4, 2024 онд 1 болж буурсан нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хэрэгжүүлэхэд Засгийн газар, УИХ-аас гарсан шийдвэрүүд нөлөөлсөнтэй холбоотой байна.

¹⁹ 1.Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

²⁰ 1.1.зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах;

²¹ 1.7.прокурорын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар эрх бүхий байгууллагад шаардлага хүргүүлэх;

1.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийхээр байна.

Төсвийн тухай хуулиар хүү, торгуулийн орлого нь аймаг болон сумын төсвийн татварын бус орлогод хамаарахаар хуульчилсан хэдий ч Гаалийн байгууллага, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар зэрэг 6 байгууллага 2023, 2024 ногдуулсан торгуулийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Зөрчил гаргасан этгээдийн торгуулийн орлогыг тухайн зөрчил гаргасан нутаг дэвсгэрийн төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй бөгөөд байгууллага бүр харилцан адилгүй дансанд төвлөрүүлж байгааг цэгцлэх шаардлагатай.

Мөн торгууль, шийтгэврийн хуудсыг хууль, журмын өөрчлөлттэй нийцүүлж өөрчлөх шаардлага үүссэн байна.

Торгууль, шийтгэврийг нэгдсэн цахим системээр бүртгэж, хянах боломжгүй, эрх бүхий албан хаагч ажиллагаа явуулж, анхан шатны баримт хөтлөн, цаасан баримтаар Прокурорын байгууллагад хянуулж байгааг анхаарч, шинэчлэл хийх болсныг илтгэж байна.

1.3.7. 2023-2024 онд ногдуулсан торгуулийн орлоготой холбоотойгоор иргэний өмчийн халдашгүй байдал зөрчөөгүй байна.

Аймгийн хэмжээнд 2023, 2024 онд нийт 103.9 сая төгрөгийн торгууль бүрэн хэрэгжээгүйг шүүхийн шийдвэрийн дагуу албадан гүйцэтгүүлэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлсэн ба 44.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд тодорхой шалтгааны улмаас хүлээгдэж байна. Харин иргэний өмчийн халдашгүй байдал зөрчигдөөгүй бөгөөд халдашгүй байдал зөрчигдөх асуудал тухайн иргэн, аж ахуйн нэгжийн хариуцлагаас шалтгаалдаг байна.

БҮЛЭГ 2. Төлөвлөсөн торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелсэн боловч орлого бүрэн төвлөрөөгүйд анхаарахаар байна.

2.1 Төлөвлөсөн торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелсэн боловч орлого бүрэн төвлөрөөгүйд анхаарахаар байна.

2.1.1. Хууль, журмын дагуу тогтоосон торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэхэд эрх бүхий байгууллага, албан тушаалтан анхаарч ажиллах шаардлагатай байна.

Торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлэх нь эрх бүхий байгууллага, албан тушаалтан байхаар хуульд заасан.

Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 1,490.0 сая төгрөгийн торгуулийн орлогыг төлөвлөж 2,090.5 сая төгрөгийг, 2024 онд 1,950.0 сая төгрөгийн торгуулийн орлогыг төлөвлөж 2,303.1 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аймгийн торгуулийн орлогын 59.0 хувийг Цагдаагийн газар, 28.0 хувийг Татварын газар, 13.0 хувийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Төрийн аудитын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар зэрэг байгууллагууд бүрдүүлсэн байна.

Хууль, журмын дагуу 2023-2024 онд тогтоосон торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлэлтийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6 Аймгийн торгуулийн орлогын ногдуулалт, төвлөрүүлсэн орлого (сая төгрөг)

Байгууллагын нэр	2023 он				2024 он			
	Ногдуулсан	Төвлөр-сөн	зөрүү	хувь	Ногдуулсан	Төвлөр-сөн	зөрүү	хувь
Авто тээврийн төв	3.1	3.1		100.0	6.8	6.8		100.0
Аймгийн ЗДТГ	1.6	1.6		100.0	20.1	17.1	3.0	85.1
Байгаль орчны газар	14.2	14.2		100.0	2.1	2.1		100.0
Гаалийн газар	8.6	8.6		100.0	2.0	2.0		100.0
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	6.5	6.0	0.5	92.4	54.6	54.6		100.0
Нийгмийн даатгалын газар	19.3	19.3		100.0	8.9	8.9		100.0
Онцгой байдлын газар	3.2	1.8	1.4	56.3	14.2	4.8	9.4	33.8
Татварын газар	480.9	474.1	6.8	98.6	1,176.9	755.9	421.0	64.2
Улсын бүртгэлийн газар	4.8	4.8		100.0	6.1	6.1		100.0
Хүнс, хөдөө аж ахуйн газар	3.8	3.8		100.0	0.3	0.3		100.0
Эрүүл мэндийн газар	6.2	6.2		100.0	9.7	9.4	0.3	96.9
Мал эмнэлгийн газар	0.3	0.3		100.0	0.2	0.2		100.0
Цагдаагийн газар	1,701.0	1,525.7	175.3	89.7	1,212.3	990.2	222.1	81.7
Дотоодын цэргийн 816-р анги					2.2	2.2		100.0
Дотоодын цэргийн 821-р анги					0.4	0.4		100.0
Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	26.7	26.7		100.0	29.7	29.7		100.0
Төрийн аудитын газар	158.3	150.3	8.0	94.9	170.9	170.9		100.0
Нийт дүн	2,438.5	2,246.5	192.0	92.1	2,717.3	2,061.5	655.8	76.9

Аймгийн хэмжээнд 2023-2024 онуудад нийт 17 байгууллагаас 5,155.8 сая төгрөгийн торгуулийг ногдуулснаас 4,308.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 847.8 сая төгрөгийн буюу 16.4 хувийн орлого төвлөрөөгүй байна.

Нийт төвлөрсөн 4,308.0 сая төгрөгийн торгуулийн орлогын 1.6 хувь буюу 67.7 сая төгрөг нь улсын төсөвт, 97.5 хувь буюу 4,228.9 сая төгрөг нь орон нутгийн төсөвт, 0.9 хувь буюу 38.7 сая төгрөг нь байгууллагын дансанд төвлөрсөн байна.

Гаалийн байгууллага, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын газар зэрэг 7 байгууллага 2023-2024 онд ногдуулсан 67.7 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.2, 23.7.2 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Аудитын судалгаагаар 2023-2024 оны төвлөрүүлээгүй торгуулийг ногдуулсан байгууллага болох Цагдаагийн газар, Онцгой байдлын газартай тулган баталгаажуулахад 55.6 сая төгрөгийг төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Мөн аудитын явцад аймгийн Засаг даргын тамгын газрын автозамын хяналтын байцаагч 3.0 сая төгрөгийг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 0.5 сая төгрөгийг, Цагдаагийн газар 29.0 сая төгрөгийг төлүүлсэн болно.

2.1.2. Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тавьсан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт 65 эрх бүхий албан тушаалтныг харьяаллын дагуу шийдвэрлэх зөрчлийг тодорхой хуульчилсан.

Орхон аймгийн аудитад хамрагдагч байгууллагын болон Прокурорын байгууллагаас ирүүлсэн судалгаагаар аймгийн хэмжээнд зөрчил хянан шийдвэрлэх 29 байгууллагын 215 эрх бүхий албан тушаалтан байна.

Дүрслэл 1 Эрх бүхий албан тушаалтны тоо, хувь



Нийт эрх бүхий албан тушаалтны 35 буюу 16.3 хувийг Цагдаагийн газрын, 39 буюу 18.1 хувийг Татварын газрын, 27 буюу 12.6 хувийг Гаалийн газрын, 27 буюу 12.6 хувийг Нийгмийн даатгалын, 18 буюу 8.4 хувийг Дотоодын цэргийн, 9 буюу 4.2 хувийг Онцгой байдлын газрын, 60 буюу 27.9 хувийг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан эзэлж байна.

2023-2024 онд эдгээр эрх бүхий албан тушаалтан 88,979 иргэн, аж ахуйн нэгжид 5,155.8 сая төгрөгийн зөрчлийн торгох шийтгэлийг оногдуулж, Прокурорын байгууллагаар хянуулсан байна.

Дээрх эрх бүхий албан тушаалтны оногдуулсан зөрчлөөс Цагдаагийн газар 87,417 иргэн, аж ахуйн нэгжид 2,913.3 сая төгрөгийн торгууль ногдуулсан нь нийт зөрчлийн 56.7 хувийг, Татварын газар 494 иргэн, аж ахуйн нэгжид 1,657.8 сая төгрөгийн торгууль ногдуулсан нь нийт зөрчлийн 32.1 хувийг тус тус эзэлж байна.

2.1.3. Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайланд мөнгөн сууриар бүртгэж, төсвийн гүйцэтгэлд үнэн зөв тусгасан байна.

Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд торгуулийн орлогыг 2023 онд 1,490.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2,090.5 сая төгрөг, 2024 онд 1,950.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2,303.1 сая төгрөг төвлөрүүлж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Хүснэгт 7 Аймаг, сумын торгуулийн орлогын гүйцэтгэл 2023, 2024 он (сая төгрөг)

Д/д	Сумын нэр	2023 он		2024 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баян-Өндөр	0.0	0.0	0.0	0.0
2	Жаргалант	40.0	58.0	100.0	102.1
3	Орхон аймаг	1,450.0	2,032.5	1,850.0	2,201.0
Нийт дүн		1,490.0	2,090.5	1,950.0	2,303.1

Торгуулийн орлогыг мөнгөн сууриар бүртгэдэг бөгөөд дутуу төвлөрүүлсэн торгуулийн авлага санхүүгийн тайланд тусгадаггүй, зөвхөн Цагдаагийн газар, Татварын газар зэрэг байгууллагууд цахим системд бүртгэлтэй байна. Зөрчил шийдвэрлэх нэгдсэн цахим системгүйгээс тайлант хугацааны орлого төвлөрүүлэлт, дутуу төлөлт зэргийг нэгтгэн гаргах боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1²², Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1²³-т заасантай нийцэхгүй байна.

2.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт нөлөөлөх нөлөөлөл бага байна.

Аймгийн 2023 оны төсвийн орлого 282,945.2 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 5,869.3 сая төгрөгөөр давсан хэдий ч 2024 оны төсвийн орлого төлөвлөснөөс 38,575.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Торгуулийн орлогын гүйцэтгэл 2023 онд 2,090.5 сая төгрөг болж, нийт орлогын 0.7 хувийг, татварын бус орлогын 7.7 хувийг эзэлсэн байна. Харин 2024 онд 2,303.1 сая төгрөгт хүрч, нийт орлогын 0.7 хувийг, татварын бус орлогын 3.5 хувийг бүрдүүлж, өссөн байна.


Хүснэгт 8. Аймгийн төсвийн нийт орлого, торгуулийн орлогын судалгаа

(сая төгрөг)

Үзүүлэлт	2023 он			Эзлэх хувь	2024 он			Эзлэх хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
Татварын орлого	238,053.6	257,455.4	19,401.8	89.7	241,749.0	245,965.1	4,216.1	79.0
Татварын бус орлого	41,817.8	29,665.5	(12,152.4)	10.3	108,811.0	65,487.8	(43,323.2)	21.0
Торгуулийн орлого	1,490.0	2,090.5	600.5	0.8	1,950.0	2,303.1	353.1	0.7
Нийт дүн	279,871.4	287,120.9	7,249.4	100.0	350,560.0	311,452.9	(39,107.1)	100.0
Нийт орлогод торгуулийн эзлэх хувь				0.7				0.7
Татварын бус орлогод торгуулийн эзлэх хувь				7.0				3.5

Торгуулийн орлого орон нутгийн төсвийн орлогод нөлөөлсөн байдлыг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл нийт орлогод 0.7-1.4 хувийг, татварын бус орлогод 2.3-8.9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 2 Торгуулийн орлогын орон нутгийн төсөвт эзлэх хувь



Татварын бус орлогод тусгай зориулалтын шилжүүлгийн буюу боловсрол, эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээс шалтгаалан нөлөөлөл багатай байсан ба 2024 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого өмнөх оноос 1 дахин өссөнөөс шалтгаалсан байна.

²² 26.1 -т "төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө",

²³ .1 -т "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө"

2.2 Торгуулиас бүрдсэн орлогыг хуваарилахдаа хууль, журамд заасантай нийцүүлээгүй байна.

2.2.1. Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс төсөв хуваарилах эрхийг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газар торгуулийн орлогын төлөвлөгөөнд заасан хэмжээгээр төсвийн төслийг тооцож, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийг өргөн барьж батлуулж байна.

Монгол Улсын Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 тоот хамтарсан тушаалаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4²⁴, 1.5²⁵-д аймгийн төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд төсөв батлахаар заасан.

Аймгийн хэмжээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд тусгай дансыг аймгийн Төрийн санд нээгээгүй бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрт зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулах зардлыг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулах төсвийг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зардалд баталж байна.

Аймгийн төсөвт төвлөрөх торгуулийн орлогоос авто замын хөрөнгө оруулалт болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг санхүүжүүлэх төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар жил бүр баталсан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь хуульд нийцүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон авто замын сангийн зардлыг хэрэгжүүлэх арга хэмжээ, улирлын байдал зэргийг харгалзан хуваарилсан байна

2.2.2. Хуваарилалтыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасантай нийцүүлээгүй байна.

Аймаг болон сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг санхүүжүүлэх төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийн төлөвлөгөө (сая төгрөг)

Зардлын нэр	2023 он орлогын төлөвлөгөө	2023 он		2024 он орлогын төлөвлөгөө	2024 он	
		Дүн	Эзлэх хувь		Дүн	Эзлэх хувь
ГХУСЗардал	1,490.0	596.0	40.0	1,950.0	780.0	40.0

²⁴ 1.4 аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн жилийн төсвийг батлахдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл /цаашид Зөвлөл гэнэ/-ийн нэрээр тусад нь нэр зааж батлахаас гадна тухайн сум, дүүргийн гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралтыг харгалзан гаргасан хуваарийг үндэслэн сум, дүүрэг тус бүрээр нэр зааж батална. Уг хөрөнгийг сум, дүүргийн батлагдсан төсөв дээр нэмж олгоно

²⁵ 1.5 батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан сум, дүүргийн төсөвт олгосон хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн нэрээр тусгай дансанд төвлөрүүлнэ

Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах зардлыг 2023 онд 596.0 сая төгрөгөөр, 2024 онд 780.0 сая төгрөгөөр буюу тухайн онд төлөвлөсөн торгуулийн орлогын дүнгээс тооцоолсон байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан торгох ял, зөрчилд оногдуулсан торгох шийтгэл, түүний биелэлтийг тодорхой гаргаагүйгээс хувь хэмжээг баримтлаагүй, нийт дүнгээс тооцсон байна.

2.2.3. Хүү, торгуулийн орлогоос зарцуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг илүү тооцсон байна.

Аймгийн Нийгмийн даатгалын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь тухайн жилийн хүүгийн орлогыг зарцуулах эрхгүй, төсөвтөө төвлөрүүлдэг байна. Харин сумдын хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн орлогыг журамд заасны дагуу зарцуулах төсвийг батлуулж, зарцуулсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1²⁶-т заасны дагуу торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 40 хувийг санхүүжилттэй нь уялдсан эсэхийг тулгахад 48.2-57.0 хувиар буюу 101.0 - 233.0 сая төгрөгөөр илүү тооцож, баталсан байна.

Цаашид орлого төвлөрүүлэх эрх бүхий байгууллага бүрээр үнэт цаасны тооцоо гаргуулан, ногдуулалт, орлого төвлөрүүлэлтийн мэдээг авч нэгтгэж, хуульд заасны дагуу хуваарилах хэрэгтэй байна.

2.2.4. Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.

Торгуулийн орлогыг Сангийн яамнаас хянасан нийт дүнгээр аймгийн хэмжээнд баталж, Татварын газар, Цагдаагийн газарт хуваарилсан ба торгуулийн орлого төвлөрүүлж буй бусад байгууллагууд торгуулийн орлого төлөвлөж, батлаагүй байна.

Аудитад хамрагдагч байгууллагад хийсэн уулзалт, ярилцлагаар торгуулийн орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үзээгүй байна.

БҮЛЭГ 3. Торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэхийг тооцоогүй байна.

3.1. Хүү, торгуулийн орлогоос Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023-2024 онд 868.7 сая төгрөг зарцуулж, үр дүнг тооцоогүй байна.

3.1.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023-2024 онд 868.7 сая төгрөг зарцуулж, үр дүнг тооцоогүй байна.

Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 тоот хамтарсан тушаалаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс

²⁶ 46.1 -т “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн ... зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ”

санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 1-5 дахь заалтад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг баталсан байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд 428.0 сая төгрөг, 2024 онд 440.7 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу зарцуулаагүй байна. Үүнд:

- Өмнөх онд төвлөрсөн торгуулийн орлогын 20 хувийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд зарцуулах байтал 2023 онд сумд 6.3 сая төгрөг, аймаг 52.3 сая төгрөгийг тухайн зардалд зарцуулсан нь нийт зардлын 12.1 хувийг эзэлж байна. Нийт зардлын 87.9 хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зарцуулсан байна.
- Төлөвлөсөн зардлаас 2024 онд хөрөнгийн зардалд 4.4 хувийг зарцуулж, 95.6 хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг өмнөх онд гарсан гэмт хэрэг, зөрчил, түүний шинж чанар, бодит нөхцөл байдалд үндэслэн дүрс бичлэгийн техник хэрэгсэл бэлтгэж байх шаардлагатай байна.

Мөн зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд хөрөнгө төлөвлөж, зарцуулах шаардлагатай нь аудитын уулзалт, судалгаагаар тодорхой болсон.

3.1.2. Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, зарцуулаагүй байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (70709) хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээнд зарцуулах төсвийг баталж, зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвийг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн үйл ажиллагааны төсөвт нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж (210801) зардлын дансанд баталж, зарцуулж байна.

Аудитаар зардлын гүйцэтгэлийг төсвийн гүйцэтгэлийн тайлангаас шалгахад ангилал хооронд зарцуулсан алдаа, зөрчил илрээгүй болно.

3.1.3. Хүү, торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ олон нийтэд хүрч, эерэг үр дүн гарсан хэдий ч зарим арга хэмжээний үр дүнг тодорхойлох боломжгүй байна.

Аймгийн хэмжээнд төвлөрсөн торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023-2024 онд нийт 868.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 2023 онд 4 зорилт 83 арга хэмжээ, 2024 онд 5 зорилт 58 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 868.7 сая төгрөгийг 1,376.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Тус төлөвлөгөөний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт хэмжигдэхүйц бус, хэт ерөнхий байдлаар тусгасан байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд 47,187 зөрчил бүртгэгдэж байсан бол 2024 онд 43,446 болж 7.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 10. Гэмт хэргийн статистик тоо

Хэргийн ангилал	2020	2021	2022	2023	2024
Гэмт хэрэг	533	504	731	761	984
Илрүүлэлтийн хувь	53.6	54.7	59.2	59.7	61.3
Үүнээс: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг	5	14	8	8	8
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	20	22	21	34	97
Гэмт хэрэг үйлдэгчээр	421	408	542	648	784
18 хүртэлх насны хүүхэд	20	23	49	54	37
Эрхэлсэн тодорхой ажилгүй	250	265	305	383	482

Гэмт хэргийн тоо 2021 онд буурч, 2022-2024 онд жил бүр өссөн бөгөөд илрүүлэлт жил бүр өссөн эерэг үзүүлэлттэй байна. Орхон аймгийн хэмжээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд онцгой анхаардаг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, зам тээврийн осол, хүүхэд үйлдсэн, хохирсон гэмт хэргүүдэд анхаарч ажилладаг. Хүүхэд үйлдсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх ашиглах гэмт хэргүүд сүүлийн жилүүдэд буурсан байна. Харин зам тээврийн гэмт хэрэг, осол сүүлийн жилд 2.8 дахин огцом өссөн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас тухайн төрлийн гэмт хэргийн бууруулахад зарцуулсан зардал үр нөлөө үзүүлээгүйг илтгэж байна.

Иймд аймгийн болон сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг төлөвлөхдөө бодит тоо, мэдээлэлд үндэслэн хүрэх үр дүнг хэмжиж боломжтой, ач холбогдолтой, шаардлагатай арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тус зөрчилд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь нийгэм, эдийн засагт зохих нөлөө үзүүлсэн байна.

Гэмт хэрэг зөрчлийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дээрх чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлсний үр дүнд нийгэм, эдийн засагт зохих эерэг үр дүн гарсан байна. Тухайлбал:

- Цагдаагийн газрын статистик мэдээллээс дүгнэвэл гэмт хэргийн илрүүлэлт 2023 онд 59.7 хувь болж өмнөх оноос 0.5 хувиар, 2024 онд 61.3 хувь болж

өмнөх 1.6 хувиар өссөн нь хэрэгжүүлсэн арга, хэмжээ олон нийтэд хүрснийг илтгэж байна.

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэмт хэрэг үйлдэгчийн тоо 2023 онд 1,132 болж өмнөх оноос 489-өөр, 2024 онд 833 болж өмнөх оноос 299-өөр тус тус буурсан нь хэрэгжүүлсэн аян, арга хэмжээ олон нийтэд хүрч, иргэдийн хариуцлага дээшилснийг харуулж байна.

3.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлсэн байна.

3.2.1. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансанд 99.0 хувьтай мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасан.

Аймаг болон сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлсэн 5 сая төгрөгөөс дээш 2023 онд 347.8 сая төгрөгийн 29, 2024 онд 362.4 сая төгрөгийн 31 зарлагын гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлж, 5.0 сая төгрөгийн 1 гүйлгээг Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдээлээгүй, аудитын явцад залруулав.

3.2.2. Эрх бүхий байгууллага нь хүү, торгуулийн орлогын зарцуулалтын тайлан, мэдээллийг олон нийтэд мэдээлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “төсөв нь улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахдаа ил тод байдлыг хангасан байх” гэж заасан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хариуцан ажиллаж байна. Аймгийн болон сумдын зөвлөлөөс хэрэгжүүлсэн ажлын мэдээ, мэдээллийг Орхойн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал цахим хаяг (фэйсбүүк), www.itkh.orkhon.gov.mn, www.orkhon.khural.mn цахим хуудсаар дамжуулан, олон нийтэд мэдээллийг хүргэж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хуваарилсан хөрөнгийн зарцуулалтыг аймгийн болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шилэн дансанд байршуулж, иргэдэд олон нийтэд мэдээлэл авах боломжийг хангасан байна.

3.2.3. Торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалд оролцогч талуудаас үнэлгээ өгөөгүй байна.

Аудитын хамрах хугацаанд иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудаас хүү торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна. Энэ нь иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоо хангалтгүй, хяналт хэрэгтэйг илтгэж байна.

БҮЛЭГ 4. Хүү, торгуулийн орлогын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан үүсээгүй, түүний бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.1 Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан үүсээгүй байна.

4.1.1. Байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан бий болгох шаардлагатай байна.

Улсын хэмжээнд торгууль, шийтгэлийн мэдээллийг бүртгэх, хянах нэгдсэн бүртгэл мэдээллийн систем бий болоогүй ба байгууллага бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн салбарын хэмжээнд мөрдөх цахим системийг ашиглаж байна. Авто тээврийн үндэсний төв, аймгийн Засаг даргын Тамгын газар гэх зэрэг байгууллагууд бүртгэлийн цахим системгүй, цахимаар торгууль төлөх боломжгүй байна.

Эндээс дүгнэвэл салбар бүрийн хяналтын систем харилцан адилгүй, торгууль, шийтгэл ногдуулах, хянах үйл явц ялгаатай, мэдээлэл солилцох боломжгүй зэрэг нь торгууль, шийтгэлийн орлогын бүртгэлийн нэгдсэн санг нэвтрүүлж, хянах шаардлагатайг илтгэж байна. Мэдээллийн нэгдсэн сан бий болсноор төрийн үйлчилгээ хурдан шуурхай болж, ажлын ачаалал буурах, үйл ажиллагаа хөнгөвчлөгдөн, торгуулийн шийтгэлийн биелэлт хугацаандаа барагдаж, иргэдийн хариуцлага дээшилж, хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэх юм.

4.1.2. Торгуулийн төлбөрийн системийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/208 дугаар тушаалаар “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн сан”-г ашиглаж эхэлсэн ба Цагдаа газар, Прокурорын газар ашиглаж хэвшсэн байна.

Цагдаагийн газрын хувьд оногдуулсан торгууль, шийтгэлийн төлбөрийг цахим систем ашиглан төлөх боломжийг бүрдүүлсэн нь эерэг нөлөө үзүүлж, орлого бүрдүүлэлтэд нөлөөлж байна.

Татварын газар нь e-tax.mta.mn цахим системээр бүртгэл, хяналтаа хэрэгжүүлж байна.

Бусад эрх бүхий байгууллагуудын хувьд төлбөрийн баримт авч баталгаажуулж байгаа нь иргэдэд төрийн үйлчилгээ шуурхай хүрэхгүйгээс орлого бүрэн төвлөрөхгүй байхад нөлөөлж байна.

4.1.3. Хяналтын систем нь орлого бүрдүүлэлтийн үр дүнд нөлөөлөхөөр байна.

Хяналтын системээр эрх бүхий албан тушаалтны зөрчлийн ажиллагааг бүрэн хянах боломж бүрдээгүй ч цагдаа, гааль, татварын байгууллагууд салбарын нэгдсэн мэдээллийн системээр бүртгэл, хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Цахим системээр удирдлагын хяналт хэрэгжсэнээр торгуулийн төлөлтийн байдал, эрх бүхий албан тушаалтны ажлын хариуцлага, орлого бүрдүүлэлт, дараагийн шатны арга хэмжээ авах зэрэгт нөлөөлөх сайн талтай юм.

Бусад торгуулийн орлого бүрдүүлдэг байгууллагууд хувьд цахим хяналтын системгүйгээс иргэд, аж ахуйн нэгж нь орлого төвлөрүүлэхгүй, хариуцлагагүй байдлыг бий болгож, хууль, журмыг мөрдөхгүй байхад нөлөөлж байна.

4.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.2.1. Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогыг барагдуулах ажлыг зохион байгуулж буй ч үр нөлөөг сайжруулахаар байна.

Аудитын нэгтгэсэн судалгаагаар Орхон аймгийн хэмжээнд 5,155.8 сая төгрөгийн торгууль ногдуулснаас 4,308.0 сая төгрөгийн орлого бүрэн төвлөрч, 847.8 сая төгрөгийн торгууль төлөөгүй үлдсэн байна.

Торгуулийн орлогыг төвлөрүүлэх, хянах, дараагийн шатны арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлэх байтал хариуцлагагүй хандсан болон дараагийн шатны арга хэмжээ хэрэгжүүлж буй шалтгаанаас орлого дутуу төвлөрч байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ”, 9.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ” гэж заасан.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2023-2024 онуудад нийт 103.9 сая төгрөгийн 117 зөрчлийн хэргийг албадан гүйцэтгэхээр хүргүүлснээс 59.5 сая төгрөгийн 96 зөрчлийг шийдвэрлэсэн бөгөөд албадан гүйцэтгүүлсэн торгуулийн орлого 57.3 хувьтай хэрэгжсэн байна.

4.2.2. Аймгийн эрх бүхий байгууллагаас хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт, шалгалт хийгээгүй байна.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь торгуулийн орлогын бүрдүүлэлтдээ эргэн хяналт хэрэгжүүлсэн байдлыг авч үзвэл зарим байгууллагуудын хяналт хангалтгүйгээс орлогыг бүрэн бүрдээгүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба аймаг, сумын торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, торгуулийн орлого төвлөрүүлж буй байгууллагын орлогод хяналт шалгалт хийгээгүй байна.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүргээ биелүүлээгүй нь Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.14²⁷-д заасантай нийцэхгүй байна.

Хүү, торгуулийн орлогоос санхүүжүүлсэн зардлаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон авто замын санд хуваарилсан зардалд төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу санхүүгийн тайлангийн аудитаар хяналт хэрэгжүүлэн ажилласан.

4.2.3. Орлого төвлөрүүлэгч зарим байгууллага торгуулийн орлогод дотоод хяналт хэрэгжүүлээгүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Шийтгэл, торгуулийн орлогыг тухайн шийдвэрийг ногдуулсан эрх бүхий албан тушаалтан бүрэн хариуцаж зөрчлийн биелэлтийн хуудсыг хэрэг бүртгэлд хавсаргаж, удирдах албан тушаалтан тухай бүр хяналтыг хэрэгжүүлдэг байна. Гэвч зарим байгууллагууд хяналт хэрэгжүүлдэггүйгээс одоог хүртэл торгууль шийтгэврийг төлөөгүй, зарим алдаа зөрчлийг дахин давтан гаргасаар байтал дараагийн шатны арга хэмжээ аваагүй, эрх бүхий албан тушаалтны ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

4.2.4. Хөндлөнгийн байгууллага, иргэн орон нутгийн хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй ба журамд хэрхэн хяналт хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй байна.

Аудитаар нийт 787.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж 55.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, орлого төвлөрүүлэх, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 731.4 сая төгрөгийн 6 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөх бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох боломжгүй байна.
- Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл, судалгаа тооцоонд үндэслэхгүй төлөвлөж байна.
- Торгуулийн орлого бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах хэрэгтэй байна.
- Төлөвлөсөн торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелсэн боловч орлого бүрэн төвлөрөөгүйд анхаарахаар байна.
- Торгуулиас бүрдсэн орлогыг хуваарилахдаа хууль, журамд заасантай нийцүүлээгүй байна.

²⁷ 17.1.14 -т "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг холбогдох байгууллагаас хагас, бүтэн жилээр гаргуулан авч, дүгнэлт хийх"

- Хүү, торгуулийн орлогоос Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023-2024 онд 868.7 сая төгрөг зарцуулж, үр дүнг тооцоогүй байна.
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлсэн байна.
- Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан үүсээгүй байна.
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА БӨГӨӨД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГАД

1. Аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлөвлөлт, зарцуулалт, үр дүнд хяналт хэрэгжүүлэх.
2. Аймгийн болон сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бодит тоо, мэдээлэлд үндэслэн хүрэх үр дүнг хэмжиж боломжтой, ач холбогдолтой, шаардлагатай арга хэмжээнд төлөвлөж, хэрэгжүүлэх.

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД

3. Эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй байдалд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, төлөвлөн, хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авч ажиллан, үнэлж дүгнэх.
4. Торгуулийн орлогоос зардал хуваарилахдаа Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд заасны дагуу төвлөрсөн орлогоос тооцох, орлого төвлөрүүлэгч байгууллагуудын биелэлтэд хяналт хэрэгжүүлэхэд ойлгомжтой байхаар харилцах дансыг хуваарилалт хийх

ОРХОН АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГАД

5. Эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

ОРХОН АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГАД

6. Татварын улсын байцаагчдын ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны 04 дүгээр сарын 05-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. Өмнөх жилийн гүйцэтгэлд үндэслэн дараа жилийн хүү, торгуулийн орлогын эх үүсвэрийг бодитой төлөвлөх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх талаар холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах
2. Хүү торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг цахим технологитой нийцүүлж, салбар хооронд уялдааг хангуулах зөвлөмжийг Сангийн яаманд уламжлах
3. Улсын төсөвт төвлөрүүлж буй байгууллагуудын торгуулийн орлогыг орон нутгийн төсвийн эх үүсвэрт төвлөрүүлэх талаарх саналыг Сангийн яаманд уламжлах
4. Иргэд төрийн цахим үйлчилгээ авах үедээ өөрийн нэр дээр оногдуулсан шийтгэл, шийдвэрлэлтийн мэдээллийг цахимаар хүргүүлэх, хэрэгжилт бүрэн хангагдаагүй тохиолдолд зарим цахим үйлчилгээг түр хязгаарлах, барагдуулсныг харгалзан эргэн сэргээх зэрэг зохицуулалтыг журамд тусгах талаар эрх бүхий байгууллагад зөвлөх.

-oOo-

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ОРХОН АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

Хандоржийн гудамж, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 0493, Факс: (976) 7035 2631,
Цахим шуудан: orkhonith33@gmail.com,
Цахим хуудас: www.itkh.orkhon.gov.mn

2025.07.23 № 35
танай _____-ны № _____-т


Хариу хүргүүлэх тухай

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
П.ПҮРЭВЛХАГВА ТАНАА

Мавзмаа
[Signature]
14/23

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитын тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

ДАРГА



Д.МӨНХБАТ



**ОРХОН АЙМГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР**

Эрх чөлөөний өргөн чөлөө, Баянцагаан баг,

Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61021

Утас: (976) 7035 0001, 7035 101

Цахим шуудан: orkhon_obg@orkhon.gov.mn

2025.07.22 № 39/183

танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
П.ПҮРЭВЛХАГВА ТАНАА**

Тус газрын улсын хяналтын байцаагч нарын хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд зөрчилгүй болгон ажиллах тул аудитын үйл ажиллагаанд өөр санал, хүсэлтгүй болно.

ДАРГА,
ХУРАНДАА




Ш.БААСАНДОРЖ

н Мавзигад

D:/2025/A5 тоот 2025

н. Мавзумаа


11/28



**ОРХОН АЙМГИЙН
ЦАГДААГИЙН ГАЗАР**

Эрх чөлөөний өргөн чөлөө, Баянцагаан баг
Орхон аймаг, 61021, Утас: (976) 70194344
Цахим шуудан: orkhon@police.gov.mn
Цахим хаяг: orkhon.police.gov.mn

2025.07.23 № 42/3807
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫНГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА ТАНАА

Тус цагдаагийн газрын 2023-2024 оны “ хүү
торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын
аудит”- аар илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан
гаргахгүй талаар анхаарч ажиллах, тус аудитын
тайлантай холбоотой санал хүсэлт байхгүй болно.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

А.ЛХАГВАДОРЖ



D:/My documents/A-5.doc

6142008269



ОРХОН АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976)7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2025.07.29 № 08/1339
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Орхон аймгийн 2024 оны "Хүү, торгуулийн
орлогын бүрдүүлэлт, зарцуулалт" аудитын тайлантай
танилцлаа.

Санал, дүгнэлтгүй.

САНХҮҮ, ТӨРИЙН САЙГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА П.ГАЛСАНСАЙНХУВЬТ



Мавзигмад
[Handwritten signature]
[Handwritten initials]

6105130873



ОРХОН АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Ш.Отгонбилэгийн гудамж, Оюут Баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61025
Утас/факс: (976) 70350965
Цахим шуудан: buzdtg@bayanundur.mn,
Цахим хуудас: www.bayanundur.mn

2025.07.22 № 02/12/2
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад
хийсэн аудитын тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ



Ч.БОЛОР-ЭРДЭНЭ

Ч.Навсрмаад

61751101058